

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/05/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. Аудитын илрүүлэлт .....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.06 № 01/49  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.ТҮМЭНБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Мэргэжлийн хяналтын газар нь Монгол улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болон татан буугдсан байна.

### Аудитын гол асуудал

Өмнөх онд зарцуулсан боловч бүртгэлээс хасаагүй байсан 61.4 сая төгрөгийн бараа материал, Хандиваар ирсэн 18.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэлд тусгаагүй байсныг байгууллагын дотоод хяналтаар тайлант онд илрүүлж бүртгэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн хяналтын газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болон татан буугдсан боловч хөрөнгө шилжүүлэх шийдвэр гараагүйн улмаас үндсэн хөрөнгө, бараа материал нь тухайн байгууллагын бүртгэлээс хасагдаагүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан

бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>115,454,278.40</b>	<b>44,798,032.79</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>5,749,023.00</b>	<b>00.00</b>
335	<b>Бусад авлага</b>	<b>5,749,023.00</b>	<b>00.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	5,749,023.00	00.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>109,705,255.40</b>	<b>44,798,032.79</b>
351	<b>Түүхий эд материал</b>	<b>8,086,891.33</b>	<b>2,859,623.75</b>
35110	Тусгай зориулалттай материал	5,008,746.04	1,999,685.84
35130	Эм боох материал	3,078,145.29	859,937.91
354	<b>Хангамжийн материал</b>	<b>101,618,364.07</b>	<b>41,938,409.04</b>
35410	Бичиг хэргийн материал	2,205,216.00	401,923.64
35420	Аж ахуйн материал	7,264,400.00	4,431,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	642,500.00	450,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,084,943.08	00.00
35450	Барилгын засварын материал	4,308,090.00	1,593,300.00
35470	Бусад хангамжийн материал	83,113,214.99	35,062,135.40
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,340,333,961.74</b>	<b>1,304,943,114.61</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,340,333,961.74</b>	<b>1,304,943,114.61</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,288,833,961.74</b>	<b>1,253,443,114.61</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,262,749,232.20	1,248,680,778.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-97,734,651.65	-127,911,718.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,357,256.76	116,357,256.76
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,022,789.23	-84,025,217.13
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	747,866,584.26	326,334,837.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-686,632,981.33	-255,178,278.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,043,905.00	48,238,244.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,792,594.27	-19,052,787.98
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>51,500,000.00</b>	<b>51,500,000.00</b>
39301	Программ хангамж	285,200.00	285,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-285,200.00	-285,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	51,500,000.00	51,500,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,455,788,240.14</b>	<b>1,349,741,147.40</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,749,023.00</b>	<b>00.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,749,023.00</b>	<b>00.00</b>
413	<b>Өглөг</b>	<b>5,749,023.00</b>	<b>00.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,749,023.00	00.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,450,039,217.14</b>	<b>1,349,741,147.40</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,450,039,217.14</b>	<b>1,349,741,147.40</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	244,694,006.84	244,694,006.84
51101	Өмч: - төрийн	244,694,006.84	244,694,006.84
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,146,453,906.45</b>	<b>1,042,896,301.02</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,197,205,929.68	1,085,056,121.06
51220	Тайлант үеийн үр дүн	-50,752,023.23	-42,159,820.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,891,303.85	62,150,839.54
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,455,788,240.14</b>	<b>1,349,741,147.40</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,069,151,552.50</b>	<b>993,683,898.64</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,582,852.50</b>	<b>77,295,998.64</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>41,582,852.50</b>	<b>77,295,998.64</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,582,852.50	77,295,998.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,002,700.00	32,408,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,580,152.50	44,887,498.64
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,027,568,700.00</b>	<b>916,387,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,023,810,700.00</b>	<b>915,787,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,023,810,700.00	915,787,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,758,000.00</b>	<b>600,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,880,000.00	600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,119,903,575.73</b>	<b>1,016,500,986.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,119,903,575.73</b>	<b>1,016,500,986.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,050,574,208.43</b>	<b>965,398,712.33</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>628,262,735.00</b>	<b>581,554,555.80</b>
210101	Үндсэн цалин	500,503,209.00	428,703,771.80
210102	Нэмэгдэл	108,676,176.00	91,760,878.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,083,350.00	22,066,499.20
210104	Урамшуулал	00.00	39,023,406.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,230,112.70</b>	<b>75,210,042.03</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,675,403.84	53,119,232.25
210202	Тэтгэмжийн даатгал	6,505,225.45	5,544,751.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,079,861.59	4,412,281.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,269,965.10	1,103,069.48
210205	Эрүүл мэндийн даатгал	12,699,656.72	11,030,706.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,210,190.00</b>	<b>71,932,761.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,857,901.00	6,202,644.00
210302	Түлш, халаалт	60,162,465.00	60,145,746.00
210303	Цэвэр, бохир ус	3,189,824.00	5,584,371.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>61,429,049.24</b>	<b>40,649,063.07</b>
210401	Бичиг хэрэг	11,125,557.54	5,535,455.99
210402	Тээвэр, шатахуун	34,399,447.94	25,363,443.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,625,222.00	6,270,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	238,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,038,821.76	3,241,364.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,023,849.00</b>	<b>1,716,100.25</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,996,860.00	185,000.25
210502	Хоол, хүнс	5,026,989.00	1,531,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>52,096,381.71</b>	<b>38,930,270.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,855,187.42	9,721,170.00
210604	Урсгал засвар	9,241,194.29	29,209,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,000,200.00</b>	<b>35,033,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	29,000,200.00	35,033,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,924,217.00</b>	<b>38,923,346.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,520,675.00	32,937,393.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,212,720.00
210803	Даатгалын үйлчилгээ	532,680.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,022.00	643,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,361,000.00	477,000.00
210807	Газрын төлбөр	217,640.00	968,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,908,200.00	1,990,433.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,397,473.78</b>	<b>81,448,774.18</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	882,000.00	7,429,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,515,473.78	70,519,774.18
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,329,367.30</b>	<b>51,102,274.17</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>32,076,667.30</b>	<b>17,018,774.17</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,076,667.30	17,018,774.17
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,250,000.00</b>	<b>1,675,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,250,000.00	1,675,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>35,002,700.00</b>	<b>32,408,500.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,002,700.00	32,408,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-50,752,023.23</b>	<b>-22,817,087.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>19,342,732.18</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	19,342,732.18
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-19,342,732.18</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-50,752,023.23</b>	<b>-42,159,820.04</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,197,205,929.68	1,500,791,240.37
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,197,205,929.68	1,500,791,240.37
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-50,752,023.23	-50,752,023.23
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,146,453,906.45	1,450,039,217.14
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,146,453,906.45	1,450,039,217.14
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-61,397,785.39	-61,397,785.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,085,056,121.06	1,388,641,431.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	3,259,535.69	00.00	3,259,535.69
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-42,159,820.04	-42,159,820.04
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,694,006.84	62,150,839.54	1,042,896,301.02	1,349,741,147.40

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,062,571,400.00</b>	<b>948,796,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,002,700.00</b>	<b>32,408,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>35,002,700.00</b>	<b>32,408,500.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>35,002,700.00</b>	<b>32,408,500.00</b>

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,002,700.00	32,408,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,027,568,700.00</b>	<b>916,387,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,023,810,700.00</b>	<b>915,787,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,023,810,700.00	915,787,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,758,000.00</b>	<b>600,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,880,000.00	600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,055,716,500.00</b>	<b>943,796,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,055,716,500.00</b>	<b>943,796,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>983,037,132.70</b>	<b>892,694,125.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>628,262,735.00</b>	<b>581,554,555.80</b>
210101	Үндсэн цалин	500,503,209.00	428,703,771.80
210102	Нэмэгдэл	108,676,176.00	91,760,878.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,083,350.00	22,066,499.20
210104	Урамшуулал	00.00	39,023,406.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>84,230,112.70</b>	<b>75,210,042.03</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,675,406.84	53,119,232.25
210202	Тэтгэмжийн даатгал	6,505,225.79	5,544,751.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,079,861.59	4,412,281.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,269,965.10	1,103,069.48
210205	Эрүүл мэндийн даатгал	12,699,653.38	11,030,706.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>70,210,190.00</b>	<b>71,932,761.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,857,901.00	6,202,644.00
210302	Түлш, халаалт	60,162,465.00	60,145,746.00
210303	Цэвэр, бохир ус	3,189,824.00	5,584,371.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>56,228,338.00</b>	<b>36,288,284.00</b>
210401	Бичиг хэрэг	10,827,863.00	5,170,600.00
210402	Тээвэр, шатахуун	33,385,090.00	21,420,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,625,222.00	6,270,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	238,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,150,163.00	3,188,884.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,585,060.00</b>	<b>11,655,530.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,084,380.00	10,226,300.00
210502	Хоол, хүнс	5,500,680.00	1,429,230.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45,082,230.00</b>	<b>31,027,760.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,999,740.00	1,818,660.00
210604	Урсгал засвар	11,082,490.00	29,209,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>29,000,200.00</b>	<b>35,033,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	29,000,200.00	35,033,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,411,267.00</b>	<b>39,062,393.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,520,675.00	33,857,393.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,212,720.00
210803	Даатгалын үйлчилгээ	532,680.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,022.00	643,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,757,000.00	757,000.00
210807	Газрын төлбөр	217,640.00	968,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,999,250.00	929,480.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,027,000.00</b>	<b>10,929,000.00</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,027,000.00	7,429,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>72,679,367.30</b>	<b>51,102,274.17</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>32,076,667.30</b>	<b>17,018,774.17</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,076,667.30	17,018,774.17
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,600,000.00</b>	<b>1,675,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600,000.00	1,675,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>35,002,700.00</b>	<b>32,408,500.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,002,700.00	32,408,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,854,900.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,854,900.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,854,900.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,854,900.00</b>	<b>5,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,854,900.00	5,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,854,900.00</b>	<b>-5,000,000.00</b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	915,787,900.0	898,769,125.8	17,018,774.2	98.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	915,787,900.0	898,769,125.8	17,018,774.2	98.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	914,112,900.0	897,094,125.8	17,018,774.2	98.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	594,824,400.0	581,554,555.8	13,269,844.2	97.8
210101	Үндсэн цалин	429,993,200.0	428,703,771.8	1,289,428.2	99.7
210102	Нэмэгдэл	99,561,200.0	91,760,878.8	7,800,321.2	92.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,670,000.0	22,066,499.2	1,603,500.8	93.2
210104	Урамшуулал	41,600,000.0	39,023,406.0	2,576,594.0	93.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,165,500.0	75,210,042.0	1,955,458.0	97.5
210201	Тэтгэврийн даатгал	52,472,600.0	53,119,232.3	-646,632.3	101.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,173,200.0	5,544,751.9	628,448.1	89.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,938,600.0	4,412,281.4	526,318.6	89.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,234,500.0	1,103,069.5	131,430.5	89.4
210205	Эрүүл мэндийн даатгал	12,346,600.0	11,030,707.0	1,315,893.0	89.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	72,715,500.0	71,932,761.0	782,739.0	98.9
210301	Гэрэл, цахилгаан	6,706,600.0	6,202,644.0	503,956.0	92.5
210302	Түлш, халаалт	60,151,700.0	60,145,746.0	5,954.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	5,857,200.0	5,584,371.0	272,829.0	95.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,087,400.0	36,054,284.0	33,116.0	99.9
210401	Бичиг хэрэг	5,198,000.0	5,170,600.0	27,400.0	99.5
210402	Тээвэр, шатахуун	21,191,600.0	21,186,000.0	5,600.0	100.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,270,700.0	6,270,700.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	238,100.0	238,100.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,189,000.0	3,188,884.0	116.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,685,600.0</b>	<b>11,655,530.0</b>	<b>30,070.0</b>	<b>99.7</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,226,300.0	10,226,300.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	1,459,300.0	1,429,230.0	30,070.0	97.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,027,800.0</b>	<b>36,027,760.0</b>	<b>40.0</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,818,700.0	1,818,660.0	40.0	100.0
210604	Урсгал засвар	29,209,100.0	29,209,100.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>35,188,300.0</b>	<b>34,667,800.0</b>	<b>520,500.0</b>	<b>98.5</b>
210702	Дотоод албан томилолт	35,188,300.0	34,667,800.0	520,500.0	98.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,489,400.0</b>	<b>39,062,393.0</b>	<b>427,007.0</b>	<b>98.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,108,800.0	33,857,393.0	251,407.0	99.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,212,800.0	1,212,720.0	80.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.0	550,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	643,900.0	643,900.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.0	143,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	757,000.0	757,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	971,700.0	968,900.0	2,800.0	99.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,102,200.0	929,480.0	172,720.0	84.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,929,000.0</b>	<b>10,929,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,429,000.0	7,429,000.0	00.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,675,000.0</b>	<b>18,693,774.2</b>	<b>-17,018,774.2</b>	<b>1,116.0</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.0</b>	<b>17,018,774.2</b>	<b>-17,018,774.2</b>	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.0	17,018,774.2	-17,018,774.2	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,675,000.0</b>	<b>1,675,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,675,000.0	1,675,000.0	00.0	100.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>915,787,900.0</b>	<b>898,769,125.8</b>	<b>17,018,774.2</b>	<b>98.1</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	915,787,900.0	898,769,125.8	17,018,774.2	98.1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>600,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>600,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>600,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>234,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	234,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>366,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	366,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>600,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>600,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэргэжлийн хяналтын газар нь Улсын их хурлаас гаргасан хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохион байгуулж байгаа ажилд дүн шинжилгээ хийж, үр нөлөөг нь сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тус байгууллага нь 2022 онд 11 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 90.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Мэргэжлийн хяналтын газар нь Монгол улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болон татан буугдсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны А/22 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналтын зөвлөлийг байгуулсан байна. Тайлант онд 7 хяналт шалгалтыг гүйцэтгэхээр төлөвлөсөн ба хэрэгжилтийг 95.7 хувьтай гэж тайлагнаж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн байна. Хяналтын зөвлөлийн тайланг МХЕГ-ын хяналт шинжилгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна.

Өмнөх онд зарцуулсан боловч бүртгэлээс хасаагүй байсан 61.4 сая төгрөгийн бараа материал, Хандиваар ирсэн 18.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бүртгэлд тусгаагүй байсныг байгууллагын дотоод хяналтаар тайлант онд илрүүлж бүртгэсэн байна.

Тус байгууллагад дотоод аудитыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хяналт тавьж хэрэгжүүлдэг ба тайлант онд ерөнхий газраас хяналт хэрэгжүүлээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны А/171 тушаалаар баталж мөрдсөн байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106.0 сая төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Дансны авлага	5.7	-	(5.7)
Бараа материал	109.7	44.8	(64.9)
Үндсэн хөрөнгө	1,340.3	1,304.9	(35.4)
Биет бус хөрөнгө	51.5	51.5	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,455.8</b>	<b>1,349.7</b>	(106.0)
Дансны өглөг	5.7	-	(5.7)
<b>Эздийн өмч</b>	<b>244.7</b>	<b>244.7</b>	-
-төрийн	244.7	244.7	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	58.9	62.2	3.3
Хуримтлагдсан үр дүн	1,146.5	1,042.9	(103.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,455.8</b>	<b>1,349.7</b>	(106.0)

Дансны авлага 5.7 сая төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материал 64.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд зарцуулсан боловч бүртгэлээс хасаагүй байсан материалыг тайлант онд зарлагадсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 35.4 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

- Хандиваар ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсныг тайлант онд тооллогоор илрүүлж 18.6 сая төгрөгөөр бүртгэсэн
- Төсвийн хөрөнгөөр 5.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 24.8 сая төгрөгийг шилжүүлэн үнэ төлбөргүй авсан.
- ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2670 тоот шийдвэрийн дагуу 2.8 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн.
- Ханх хилийн боомтын экспорт, импорт хорио цээрийн хяналтын хэлтэс Ханхын Гаалийн хэлтэс рүү шилжсэнтэй холбоотойгоор ТӨБЗГ-ын 2022 оны өдрийн 90-р тогтоолын дагуу 475.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнзэргээс шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 5.7 сая төгрөгийг тайланд онд төлж өр төлбөргүй тайлагнасан байна.

Хуримтлагдсан үр дүн 103.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,058.8 сая, нийт зарлагыг 1,058.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 211.2 сая төгрөгөөр бууруулж, 847.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 68.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 915.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 915.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 32.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 898.8 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа ба 17.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70417</b>	<b>Мэргэжлийн хяналт</b>	<b>915.8</b>	<b>898.8</b>	<b>17.02</b>	<b>98.1</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	882.0	865.2	16.77	98.1
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.8	0.8	-	100.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	25.7	25.6	0.16	99.4
80227	Лабораторийн итгэмжлэл	5.6	5.5	0.09	98.4
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1.7	1.7	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс мөсний баярын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхтэй холбогдуулж хуваарилсан 0.6 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч тайлагнасан байна.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 0.2 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,119.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 17.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага 17.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 15.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 0.8 сая төгрөг
- Албан томилолтын зардлаас 0.5 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Мэргэжлийн хяналтын газар нь Монгол улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолын дагуу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болон татан буугдсан байна. Тус тогтоолын дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллаж байгаа улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу байгууллагад шилжүүлсэн байна. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй эд хөрөнгийг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхээр заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны II улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж 3 зөвлөмжийг өгсөн байна. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж алдаа зөрчлийг арилгасан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын бүртгэл, тайлагнал, материалын эмх цэгц, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	539.6	3	100	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>539.6</b>	<b>3</b>	<b>100</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар өмнөх онд зарцуулсан боловч бүртгэлээс хасаагүй байсан 61.4 сая төгрөгийн материалыг тайлант онд зарлагдахдаа тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг залрууллаа.

#### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг зарлагдахдаа зардлыг буруу хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	61.4			1	61.4	1	61.4		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>61.4</b>			<b>1</b>	<b>61.4</b>	<b>1</b>	<b>61.4</b>		

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: 2023.02.01